

ММСГНийгэмлэгийн 2024 оны үйл ажиллагааны тайлан

ММСГНийгэмлэгээс тайлангийн хугацаанд хэрэгжүүлсэн ажлын талаар:

А. Зохион байгуулалт, сурталчилгааны чиглэлээр

1. Нийгэмлэгийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөний төсөл дээр Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг авч тусган боловсруулж, УЗ-ийн даргаар батлуулан хэрэгжилтийг хангаж ажиллалаа. Нийт 26 заалт бүхий төлөвлөгөөний хэрэгжилт 20 ажил бүрэн хэрэгжсэн, 5 ажил огт хэрэгжээгүй, 2 ажил хагас биелэлттэй ерөнхий гүйцэтгэл 81% байна.

2. Нийгэмлэгийн үйл ажиллагааны тайланг „Төрийн бус байгууллагын тухай хууль”-ийн дагуу Улсын Бүртгэлийн Газарт дараа оны 2-р сарын 15-ны дотор албан ёсоор гарган өгч ажилласан ба татвар, нийгмийн даатгалын төлбөр, тооцоо, тайланг хуулийн хугацаанд хийж, тайлагнаж ирлээ.

3. Нийгэмлэгийн үндсэн зорилт, үйл ажиллагаа, тайлан болон цаашид хэрэгжүүлэх ажлын талаар гишүүн байгууллагууд, ААНБ, хувь хүмүүст танилцуулах, сурталчлах, гагнуурын мэргэжлийг олон нийтэд түгээх зэрэг ажлууд байнга явууллаа.

4. Мэргэжлийн туслалцаа авах, хамтран ажиллах, ажил төрлийн холбоо тогтоох, сургалтанд хамрагдах, зөвөлгөө авах чиглэлээр нийгэмлэгт хандсан ААНБ, хувь хүмүүст туслалцаа үзүүлж ажиллалаа.

5. Монголын анхны гагнуурын мэргэжлийн „Гагнуур” сэтгүүлийн 5 дахь дугаарыг дангаар гаргаж гишүүн байгууллагууд, ААНБ, хувь хүмүүст тараан ажиллаж байна. Сэтгүүлийн энэ дугаарт мэргэжлийн гагнуурчдын ур чадварын аваргын тэмцээний дүн, ДЦС-3 ТӨХК-ийн Металл судлал, гагнуурын лабораторийн эрхлэгч Л.Энхбаярын талаарх нийтлэл, Гагнуурын нэгдсэн төвд хувиараа хөдөлмөр эрхлэгч, залуу гагнуурчин эмэгтэй Н.Баярмаагийн ярилцлага, нийгэмлэгийн үйл ажиллагааны товч мэдээлэл, гагнуурын шинэ техник технологи мэргэжлийн хичээл зэрэг материалуудыг гаргасан.



6. Нийгэмлэгийн www.mmsws.mn веб сайтад нийгэмлэгийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг тогтмол тавьж ажиллаж байна.

7. МҮХАҮТанхимын дэргэд Эрчим хүчний зөвлөлийн хурал, Үндэсний итгэмжлэлийн төвөөс зохион байгуулсан арга хэмжээ, Эрчим хүчний яамны тусгай зөвшөөрлийн хэлэлцүүлэг, Боловсрол шинжлэх ухааны яамны уулзалт семинар, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сургалт, үнэлгээ, судалгааны институт, „Монгол ур чадвар-2024”-ын зохион байгуулах ажлын хэсгийн хурлууд зэрэг арга хэмжээнүүдэд гүйцэтгэх захирал болон нийгэмлэгийн төлөөлөл оролцож санал бодлоо илэрхийлж ажиллав.

8. Малайз улсад 2024 оны 11-р сард Азийн гагнуурын холбооны аудиторын шалгалтыг Хасу Даян ХХК-ийн чанарын инженер Б.Сэлэнгэ, Б.Намуундарь нар өглөө.

Азийн гагнуурын холбооны аудиторын шаардлага хангах шалгалтанд Б.Намуундарь бүрэн тэнцэж Б.Сэлэнгэ тестээ амжилттай дуусгаж ярилцлагад орохоор болов.

Үр дүнд нь АГХ-ы анхны аудиторууд Монголд бий болж байна.

9. Иргэний нийгэм, мэргэжлийн төрийн бус байгууллагуудтай МАНамын зүгээс хамтран ажиллах санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээ Тусгаар тогтнолын ордонд 2024 оны 6-р сарын 18-нд болов.



МАН-ын ерөнхий нарийн бичгийн дарга Д.Амарбаясгалан 180 орчим ТББ-ын удирдлагуудтай тус тусад нь санамж бичиг байгуулж гарын үсэг зурав

ММСГН-ийг төлөөлж гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн уг арга хэмжээнд оролцон гарын үсэг зурлаа.

10. ТТПКоллеж 2024 оны 5-р сарын 16-нд мэргэжлийн боловсролын багш нартай чөлөөт ярилцлага явагдаж салбарын тулгамдаж буй асуудал, гагнуурчин бэлтгэх тогтолцоо, төлбөрийн шинэчлэл, гагнуурын стандартын талаар хэлэлцэв. Хэлэлцүүлэгт ММСГНийгэмлэгийн гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн, нийгэмлэгийн инженер С.Батсайхан нар оролцож санал бодлоо хуваалцаж нийгэмлэгийн талаар танилцууллаа.

11.МҮХАУТанхимын дэргэдэх эрчим хүчний зөвлөлийн хурлуудад нийгэмлэгийг төлөөлөн гүйцэтгэх захирал тогтмол оролцов. Мөн „Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай” хуулийг хэрэгжүүлэх үүднээс Салбарын нэгдсэн холбоо анхлан байгуулахад оролцон ММСГН гишүүнчлэлээр орохоор болсон.

12.Нийгэмлэгийн атестатчлалын сертификатыг шинэчлэн Үндэсний итгэмжлэлийн Төвийн лого оруулан, уг байгууллагаас зөвшөөрөл олгосон дардас ашигладаг болгон өөрчилж бичвэрүүдийг шинэчлэв.

Б. Атестатчлал, сургалт, стандартын чиглэлээр

1.Тохирлын үнэлгээ-Ажилтны баталгаажуулалтын байгууллагад тавих ерөнхий шаардлага стандарт буюу аливаа баталгаажуулалт хийдэг байгууллагад тавигдах шаардлагуудыг тусгасан Монгол улсын үндэсний стандарт MNS ISO/IES 17024-ыг ханган биелүүлэх чиглэлээр ажиллалаа.

2.MNS ISO/IES 17024 стандартын дагуу ГШБТөвөөс Оюутолгой ХХК-ийн 86,MCS property LLC 22, Эм Пи Ай Консалтантс ХХК,Хасу Даян ХХК тус бүр 10,HANGXIAO STEEL STRUCTURE Co Ltd ,Зэт Эм И ХК тус бүр 8, Хаанзаа сервис ХХК, Хан оч марал ХХК тус бүр 4, Барилга ХХК Жи Эс Кон Метал ХК, MCS Coco-Cola-LLC, BDG-инженеринг тус бүр 2,Инкон ХК 1, ГММБС 281, хувиараа 5 гагнуурчин нийт 16 компани, ААНБ болон хувь хүн зэрэг нийт 448 гагнуурчнаас гагнуурын мэргэжлийн атестатчлалын шалгалт авч сертификат, гэрчилгээ олголоо.

3. FLSmidth Mongolia компанийн захиалгаар Оюутолгойн Double-Deck Service Cage COP781-1 төхөөрөмжийн угсралтын эд ангийн хөнгөн цагааны хайлш хагас автоматаар гагнах гагнуурын 9 технологи, аргон гагнуураар гагнах гагнуурын 9 технологи/Welding Procedure Specification/-ийг олон улсын холбогдох стандарт, техникийн гарын авлага, дүрмийн дагуу ОУГИнженер С.Батсайхан боловсруулсныг албан ёсоор баталгаажуулснаар угсралтын ажилд ашиглан үр дүнгээ өгч байгаа болно.

4.ММСГНийгэмлэг ГММБСургуультай хамтран 2024 оны 1-р сарын 29-нд гагнуурын сургалт явуулдаг коллеж, мэргэжил сургалтын төвүүдийн багш нарт зориулсан гагнуурын стандарт, гадна, дотоод үзлэг, хэмжилт хэрхэн хийх зэрэг сэдвүүдээр онол, дадлага хосолсон нэг өдрийн үнэ төлбөргүй сургалт зохион байгууллаа.

Уг сургалтанд Улаанбаатар,Эрдэнэт,Налайх,Архангай,Өмнөговь,Дорноговь зэрэг хот,аймгуудаас ирсэн гагнуурын 17 багш оролцов. ММСГН-ийн гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн нийгэмлэгийн үйл ажиллагаа,зорилго, чиглэлийн талаар танилцуулга хийж, инженер С.Батсайхан /ММСГН/, мэргэжилтэн Н.Ганхуяг/ММСГН/, О.Мөнхтөгс /Lynux ХХК/, аудитор Б.Сэлэнгэ /Хасу Даян ХХК/ нар хичээл сургалт явууллаа.

ГММБСургуулийн захирал Э.Гантулга гагнуурын сургуулиа танилцуулах ажил хийв.



5.ММСГНийгэмлэгээс MCS International ХХК ийн хүсэлтээр 2024 оны 2-р сарын 01-нд тус компанийн инженер техникийн залуу ажилтнуудад зориулсан сургалт зохион байгуулав.



Confort plaza-д болсон дээрх сургалтаар гагнуурын чанарын бүлэг стандарт, гагнах арга ажиллагаа, жишмэл тэмдэглэгээ, дотоод, гадаад үзлэг, үл эвдэх сорил зэрэг нийт 6 стандартыг танилцуулан хэрхэн ашиглах талаар зөвлөгөө өгч, асуултанд хариулав.

Сургалтанд зөвлөх инженер Дорж /ММСГН/, аудитор Б.Сэлэнгэ /Хасу Даян ХХК/, О.Мөнхтөгс /Лунх ХХК/, Н.Ганхуяг/ММСГН/, нар хичээл зааж, тус компанийн 15 ажилтан хамрагдлаа.

6. ОХУ-ын Эрхүү мужийн мэргэжлийн боловсролын байгууллагуудын захирлуудтай ММСГН, Хасу мегаватт ХХК, ГММБС, Лунх ХХК-ийн удирдлагууд оролцсон уулзалт 2024 оны 5-р сарын 24-ний өдөр ГММБС дээр зохион байгуулагдав.

Уг уулзалт ярилцлаганд нийгэмлэгийн гүйцэтгэх захирал Н.Мягмарсүрэн оролцож ММСГН-ийн үйл ажиллагаа, зорилго, чиглэлийн талаар танилцуулга хийж асуултанд хариуллаа.



7.ММСГНийгэмлэг, ХНХЯамны харьяа ХНХСҮСИнститут, ГММБСургууль хамтран Дэлхийн банкны санхүүжилт бүхий Эрэлтэд нийцсэн ур чадвар олгох хөтөлбөр"-ийн хүрээнд 7 өдрийн гагнуурын сургалтыг 2024 оны 9-р сарын 23-29-ны өдрүүдэд зохион байгуулав.

ГММБС дээр болсон уг сургалтад Улаанбаатар төмөр зам, ДЦС-3 ТӨХК, ДЦС-4 ТӨХК, Дархан ус суваг ХХК, Улаанбаатар ДС ТӨХК, Зэт ЭМ ХХК, Хасу мегаватт ХХК зэрэг байгууллагуудын 15 гагнуурчин гагнуурын мэргэжлийн онол, дадлагын хичээл заалгаж, мэргэжлийн түвшнээ сайжрууллаа.



8. Нийгэмлэгийн зүгээс 2024 оны 9-р сарын 26-нд Номин констракшин ХХК-ийн хүсэлтээр тус байгууллагын гагнуурчдад гагнуурын мэргэжлээр нэг өдрийн сургалтыг ажлын байран дээр нь зохион байгууллаа.

Онол, дадлага хосолсон уг сургалтанд тус компанийн 17 гагнуурчин хамрагдав.

9. Герман Монголын мэргэжлийн боловсролын сургуулийн гагнуурын мэргэжлийн төгсөгчдийн мэргэжлийн үнэмлэх сертификат олгох ёслолын арга хэмжээ 2024 оны 6-р сарын 12-ны өдөр боллоо.

ММСГ Нийгэмлэг нь ГММБ Сургуультай хамтран ажиллах гэрээний дагуу тус сургуулийн төгсөгчдөд ISO/IEC 17024:2012 (MNS ISO/IEC 17024:2014) стандартын шаардлагын хүрээнд баталгаажуулалт хийж сертификат үнэмлэх олгон ажиллаж байна.

Нийгэмлэгийн шинэчилсэн сертификатыг 2024 оны 6-р сарын 12-ны өдөр тус сургуулийн 42 төгсөгч гардан авлаа.



10. ТИС ийн харьяа Механик инженерийн сургуулийн гагнуурын чиглэлийн мэргэжлийн анхны ангийн хичээлийн хөтөлбөрийн хэрэгжилтээр тус сургуулийн багш профессор Галаатай хамтран дадлагын ажлыг хаана ямар сэдвээр хийх талаар ярилцлага уулзалт хийж үйлдвэрийн баазтай танилцуулж улмаар сэдвүүдээр санал боловсруулж илгээсэн

В. Мэргэжлийн ур чадварын уралдаан тэмцээний чиглэлээр

1. ММСГНийгэмлэгээс Монголын мэргэжлийн гагнуурчдын ур чадварын улсын аваргын 7дахь удаагийн тэмцээнийг 2024 оны 11-р сарын 28, 29, 30-ны өдрүүдэд ГММБСургууль дээр амжилттай зохион байгуулж 12-р сарын 01-нд шүүгчид дүнгээ гаргалаа.

Тэмцээн

1. Бүрхүүлт электродтой гар нуман гагнуур (111/ SMAW) буюу цахилгаан гар нуман гагнуур,

2. Идэвхтэй хийн хамгаалалттай нуман гагнуур (135/ GMAW) буюу хагас автомат гагнуур,

3. Идэвхгүй хийн хамгаалалттай вольфрамон электродтой нуман гагнуур (141/ GTAW) буюу аргон гагнуур гэсэн 3 төрлөөр Монгол улсад болон олон улсад мөрдөгдөж буй гагнуурын стандарт, тэмцээний удирдамжийн дагуу явагдсан.

Энэ жилийн тэмцээн “ Гагнуурчдын өдөр ”/Welders day/ гэсэн уриан дор боллоо.

Тэмцээний ерөнхий ивээн тэтгэгчээр MineSpec ХХК ажиллаж эхний 3 байранд орсон гагнуурчдыг ESAB брэндийн гагнуурын аппарат, гагнуурын хэрэгслээр нэмж урамшуулав.

ГММБСургууль, Хасу металз ХХК, Лайнюкс ХХК, ZMEngineering ХХК-ууд хамтран ажиллаж ивээн тэтгэж тусалцав.

Тэмцээнд хот, хөдөөгийн 40 гаруй байгууллагыг төлөөлсөн 16-57 насны, давхардсан тоогоор 144 гагнуурчин өрсөлдсөнөөс 3 эмэгтэй гагнуурчин байлаа.

Ерөнхий шүүгчээр ММСГН-ийн ажилтан, гагнуурын олон улсын инженер С.Батсайхан ажиллав.

Тэмцээний дүнгээр:

1. Цахилгаан гагнуурын төрөлд 72 гагнуурчин өрсөлдсөнөөс /Авбал зохих оноо 260/

1-р байранд 222 оноо/85.4%/ Ж.Жанлав-Ойдов /Оюутолгой ХХК/

2-р байранд 183 оноо/70.4%/ С.Мөнх-Эрдэнэ /ДЦС-4 ТӨХК/

3-р байранд 177.5 оноо/68.3%/ Э.Батсүх /ДЦС-4 ТӨХК/

2.Хагас автомат төрөлд 36 гагнуурчин өрсөлдөж /Авбал зохих оноо 260/

1-р байранд 241 оноо /92.69%/ Д.Нямрагчаа /Хувиараа/

2-р байранд 233 оноо/89.62%/ Ж.Жанлав-Ойдов /Оюутолгой ХХК/

3-р байранд 159.5 оноо / 61.35%/ Б.Өлзийбуян /Хасу Мегаватт ХХК/

3.Аргон гагнуурын төрөлд 36 гагнуурчин өрсөлдөн /Авбал зохих оноо 260/

1-р байранд 241.5 оноо/92.88%/ З.Норовбат /MCS property ХХК/

2-р байранд 241 оноо/92.69%/ Ч.Агваандэмбэрэл /ДЦС-4 ТӨХК/

3-р байранд 239 оноо/91.92%/ М.Сүхбат /ГММБС/ нар тус тус орлоо.

Түрүүлсэн гагнуурчин 1,000,000 төгрөгийн мөнгөн шагнал, ESAB брэндийн 1,463,000 төгрөгийн үнэ бүхий гагнуурын аппарат

2-р байранд орсон гагнуурчин 600,000 төгрөгийн мөнгөн шагнал, ESAB брэндийн 324,500 төгрөгийн үнэ бүхий гагнуурын баг

3-р байранд орсон гагнуурчин 400,000 төгрөгийн мөнгөн шагнал, ESAB брэндийн 225,500 төгрөгийн үнэ бүхий гагнуурын баг тус тус шагналд авлаа.

Тэмцээнд амжилттай оролцсон гагнуурчин эмэгтэй Г.Номин /Өмнөговь ПК/-г БНСУлсын CRETOS маркийн цахилгаан гагнуурын аппаратаар урамшуулав.



2.Техник технологийн политехник коллежийн гагнуурын ахмад багш С.Баяраагийн нэрэмжит мэргэжлийн ур чадварын нээлттэй тэмцээнийг 2024 оны 5-р сарын 15-17-ний өдрүүдэд ТТПК дээр тус сургуулийн захиргаа зохион байгуулав.



ММСГНийгэмлэг тэмцээнийг явуулахад мэргэжлийн туслалцаа үзүүлэн хараат бус шүүгчдийн бүрэлдэхүүн зохион байгуулж, хамтран ажиллалаа.

Гагнуурын мэргэжлийн тэмцээн 1-р модулийн дагуу явагдаж хот, хөдөөгийн нийт 14 сургуулийн 18 суралцагч хамрагдав.

Тэмцээний шүүгчдийн үнэлгээгээр тэргүүн байранд Өмнөговь ПКоллежийн суралцагч Г.Номин 9.6 оноогоор, дэд байранд Өмнөговь ПКоллежийн суралцагч Г.Сүхбаатар, ГММБСургуулийн суралцагч М.Сүхбат нар 7.7 оноогоор шалгарч шагнал хүртлээ.

3.Францын Лион хотод 2024 оны 9-р сард болсон Дэлхийн ур чадварын /WORLD SKILLS-2024/ 47-р тэмцээнд Монгол улс 7 мэргэжлийн төрөлд оролцлоо.

Тус нийгэмлэгийн үе шаттай зохион байгуулж шалгаруулсан Монгол ур чадвар тэмцээний ялагч Өмнөговь аймгийн Политехник коллежийн суралцагч Б.Чухал амжилттай оролцон 704 оноо авснаар дэлхийн стандарт хангаж „Medallion for excellence” хүртлээ.

Уг тэмцээнд гагнуурын үндэсний экспертээр Оюутолгой ХХК-ийн гагнуурын багш Ц.Хашмөрөн ажилласан юм.

Гагнуурын оролцогчийг бэлтгэхэд зориулан ММСГН БШУЯ-ы холбогдох байгууллагатай гэрээ байгуулж 10 сая төгрөгийн материал авч өгсөн.

Дэлхийн ур чадварын гагнуурын төрөлд нийт 37 орны залуучууд өрсөлдсөнөөс БНСУ-ын оролцогч 736 оноогоор алтан медаль, БНХАУ-ын оролцогч 733 оноогоор мөнгөн медаль, Канад, АНУ, Австралийн оролцогч нар 727-729 онооны үзүүлэлтээр хүрэл медалийн эзэд болжээ.

Гагнуурын төрөлд нийт 14 орны оролцогч нар 701-723 оноо авч „Medallion for excellence”-ийн болзол хангасан байна.



4. БНХАУ-ын Гу-Ан хотод 2024 оны 10-р сарын 25-30-нд болсон гагнуурын ур чадварын олон улсын ARC CUP-2024 тэмцээнд манай залуу гагнуурчид амжилттай оролцлоо

Уг тэмцээнд Энэтхэг, ОХУ, ХБНГУ, Иран, Сингапур, Синегал, Вьетнам, Монгол улсын гагнуурчид хоорондоо өрсөлджээ.

ММСГН-ийн зохион байгуулсан Монголын 3 хүнтэй баг оролцож ,цахилгаан гагнуур хийцийн төрлүүдэд М.Сүхбат /ГММБС/ алт, хагас автомат төрөлд Ө.Төгсбаяр /Зэт ЭМ ХХК/, алт цахилгаан гагнуурын төрөлд Э.Тэмүүжин /Хасу Даян ХХК/ мөнгөн медаль хүртсэн.

Тэмцээнд оролцох гагнуурчдыг шалгаруулах, бэлдэх ажлыг ГММБСургууль,нийгэмлэгтэй хамтран амжилттай зохион байгуулав.

Нийгэмлэгийн зүгээс бэлтгэл ажлын санхүүжилтийн 50%, багаж хэрэгслийг 100% хариуцан шийдвэрлэсэн.



Г. Гадаад харилцаа, хамтын ажиллагааны чиглэлээр

1.ММСГНийгэмлэг АГХолбооны бүрэн гишүүний хувиар үйл ажиллагаанд нь оролцож, гишүүнчлэлийн хураамжаа цаг тухайд нь төлж ажиллаж байна.

Малайзын Bandar Baru Bangi хотод Азийн гагнуурын 41 дэх хурал 2024 оны 11-р сарын 7,8,9-ний өдрүүдэд боллоо.

Уг хуралд ММСГНийгэмлэгийг төлөөлж нийгэмлэгийн Удирдах зөвлөлийн гишүүн О.Мөнхтөгс, Хасу Даян ХХК-ийн чанарын инженер Б.Сэлэнгэ нар оролцов.

Хуралд Япон, Сингапур, Индонез, Малайз, БНСУ, Филиппин, Энэтхэг, БНХАУ, Мьянмар, Монгол зэрэг орнуудын төлөөлөгчид оролцсон байна.

Хурлаар гагнуурын чанарын шалгалтыг сайжруулах, аудитын хорооны гэрчилгээ олгох бүтэц эргэн тайлагнах талаар хэлэлцүүлэг хийлээ. Аудит, гэрчилгээжүүлэлт, стандартын дэд хороодын хэлэлцүүлэг явагдав.

Азийн гагнуурын технологийн 16 дахь семинар /форум/ үзэсгэлэн 2024 оны 11-р сарын 6-ны өдөр Малайзын Куала Лумпурын их сургууль дээр явагдаж, гагнуурын салбарт тулгарч буй асуудлууд, гагнуурын ур чадварын гэрчилгээжүүлэх систем, гагнуурын дэвшилтэт технологиудын талаар Япон, Малайз, Энэтхэг зэрэг орнуудын төлөөлөгчид илтгэл тавьсан байна.



Тайлан бичсэн/Н.Мягмарсүрэн/
2025 оны 02 сарын 06

